

ГОВЬ-АЛТАЙ АЙМГИЙН ТӨРИЙН БАЙГУУЛЛАГА, АЛБАН ТУШААЛТАНД ИРҮҮЛСЭН ӨРГӨДӨЛ, ГОМДЛЫН 2025 ОНЫ III УЛИРЛЫН ТАЙЛАН

2025.09.30

Алтай хот

Монгол Улсын Засгийн газрын 2005 оны 67 дугаар тогтоолын дагуу иргэдээс төрийн байгууллага албан тушаалтанд ирүүлсэн өргөдөл, гомдлын 2025 оны 2 дугаар улирлын тайланг Засгийн газрын иргэд олон нийттэй харилцах-1111 төвөөс шилжин ирсэн болон аймгийн 18 сум, 24 агентлаг, аймгийн Засаг даргын Тамгын газарт ирсэн өргөдөл, гомдлын тайлан мэдээг нэгтгэн дүгнэлээ.

Байгууллагын дотоод асуудал, үйлчилгээ авахтай холбоотой хүсэлтийг хасаж, бусад асуудлаар 118 хүсэлт, төрийн байгууллагын албан хаагчид хүргүүлсэн талархал 7, төрийн байгууллага, албан тушаалтны шийдвэр, үйл ажиллагаагаар иргэдийн хуулиар хамгаалагдсан эрх чөлөө, ашиг сонирхол зөрчигдсөн гэж үзэж сэргээлгэхээр гаргасан 24 гомдлыг хүлээн авч ажиллалаа.

Тайлант хугацаанд аймгийн Засаг даргын Тамгын газар, хэлтэс, агентлагууд болон сумдаас нийт 151 өргөдөл, гомдол, санал, хүсэлт ирүүлснээс 127 буюу 84.1%-ийг хуулийн хугацаанд шийдвэрлэсэн ба 23 өргөдөл шийдвэрлэгдэх шатандаа, Засгийн газрын Иргэд олон нийттэй харилцах төвд ерөнхий боловсролын сургуулийн анги танхимын тохижилтын мөнгө хураасантай холбоотой 1 өргөдөл гомдлыг тус тус шийдвэрлэхээр хяналт тавин ажиллаж байна.

Төрийн албан хаагчийн ур чадвар, ёс зүй, эрүүл мэндийн тусламж үйлчилгээтэй холбоотой 8 өргөдөл ирсэн буюу нийт өргөдөл гомдлын 5.2%-ийг эзэлж байна.

Говь-Алтай аймгийн хүн амын дундаж наслалтыг 80-аас дээш хүргэх зорилготой “Говь-Алтай 80+” эрүүл мэндийн хөтөлбөрийн хүрээнд 2024 оны 09 дүгээр сарын 08-ны өдрөөс 2025 оны 09 дүгээр сарын 14-ний өдөр хүртэл Эрүүл мэндийн газрын дарга О.Баатарчулуунаар ахлуулсан 24 хүний бүрэлдэхүүнтэй ажлын хэсэг Алтай, Халиун сумдын иргэдийг урьдчилан сэргийлэх, эрт илрүүлэг үзлэгт хамруулан, мэдээлэл сургалт сурталчилгааны ажлыг зохион байгууллаа. Явуулын эмнэлгийн урьдчилан сэргийлэх үзлэгт 320, эрт илрүүлэг үзлэгт 372 нийт 692 иргэнд эрүүл мэндийн тусламж үйлчилгээг үзүүлсэн байна. Эрт илрүүлэг, оношилгоо шинжилгээнд хамрагдсан иргэдийг насны бүлгээр авч үзвэл 18-30 насны 49, 31-45 насны 119, 46-60 насны 47 иргэн, 61 дээш насны 57 иргэн хамрагдсан байна.

Төрийн албан хаагчийн ёс зүйн тухай хууль, ёс зүйн хэм хэмжээний талаар 934 төрийн албан хаагчийг сургалтад хамруулан ажилласан. Эрүүл мэндийн салбар, эмнэлгийн мэргэжилтний ёс зүйн хэм хэмжээний сургалтад 20 эрүүл мэндийн байгууллагын 297 эмч, эмнэлгийн мэргэжилтэн хамрагдсан байна.

Боловсролын салбарын төрийн албаны ёс зүйн сургалтад 9 сумын 350 албан хаагч танхимаар, сургууль цэцэрлэгийн захирал, ёс зүйн хорооны 450 албан хаагч цахимаар сургалтад хамрагдлаа.

Хүүхдэд, гэр бүлийн хөгжил, хамгааллын газарт ирсэн хүүхдийн эрхийн зөрчил, мөнгөн тэтгэмжтэй холбоотой 7 гомдол мэдээллийг судлан, сумдын хамтарсан багт арга зүйн зөвлөмж өгч, кейс шийдвэрлэлтэд хяналт тавин ажиллаж байна.

Хот тохижилт амьдрах орчинтой холбоотой 6 өргөдөл буюу 3,9%-ийг эзэлж байна.

Хот тохижилт орчны бохирдлыг бууруулах замаар хог хаягдлыг ангилан ялгах дадлыг хэвшүүлэх, аюултай хог хаягдлын оновчтой менежментийг хэрэгжүүлэн, химийн хорт аюулт бодисыг мэргэжлийн байгууллагаар устгуулах, дахиврыг эдийн засгийн эргэлтэд оруулах, сумдын төвлөрсөн хогийн цагийг стандартын шаардлагад нийцүүлэх, хүний эрүүл аюулгүй орчинд амьдрах орчныг бүрдүүлэхээр тусган ажиллаж байна.

Хандив тусламж дэмжлэг хүссэн иргэдийн өргөдөл хүсэлтийг хүлээн авч, аймгийн Засаг даргын Удирдлагын зөвлөлийн хурлаар хэлэлцүүлэн сургалтын төлбөр, тэмцээн уралдаанд оролцох замын зардал, эмчилгээний төлбөрийг шийдэж дэмжлэг үзүүллээ.

АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН ТАМГЫН ГАЗАР